

88566535

УЛААНБААТАР ЦАХИЛГААН ТҮГЭЭХ СҮЛЖЭЭ
ТӨРИЙН ӨМЧИТ ХУВЬЦААТ КОМПАНИ



ТЕХНИКИЙН НӨХЦӨЛ

Дугаар 01/01579/23

2023 оны 11 сарын 1 өдөр

Улаанбаатар хот

Нэг. Ерөнхий мэдээлэл

1.1	Хүсэлтийн дугаар	231000962
1.2	Хэрэглэгчийн нэр, регистр:	ХАН-УУЛ ДҮҮРГИЙН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗАР, РД:9120335
1.3	Хэрэглэгчийн байршил:	Улаанбаатар Хан-Уул 13-р хороо, - Хан-Уул дүүргийн 13-р хороо 4, 5а, 5б-1, 5б-2, 6-р хэсгүүдийн айл
1.4	Ажил үйлчилгээний зориулалт:	Инженерийн байгууламж
1.5	Техникийн нөхцөл олгох үндэслэл:	1.5.1) Хан-Уул дүүргийн засаг даргын тамгын газрын 2023 оны 10 дугаар сарын 06-ны өдрийн №03/1592 албан хүсэлт. 1.5.2) Өмнө нь авсан 2021-10-29-ны өдрийн 15/05354/21 тоот техникийн нөхцөлийн хугацаа сунгуулах хүсэлт.
1.6	Техникийн нөхцөлийн ангилал:	Өмнө нь авсан техникийн нөхцөлд өөрчлөлт оруулах, Хугацаа сунгуулах
1.7	Суурилагдсан хүчин чадал	400 кВА (Дөрвөн зуун кВА)
1.8	Хүчдэлийн түвшин	6кВ

Хоёр. Холболтын цэг

- | | |
|-----|---|
| 2.1 | 35/6 кВ-ын Био /хуучин/ дэд станцаас 6 кВ-ын Био-1 фидерийн КТПН-6321 дэд өртөөний 0,4 кВ талаас шинээр гаргалга гаргаж бүрээстэй агаарын шугам татаж АТП-5163, АТП-1681 дэд өртөөнүүдийн ачаалал хөнгөлөх. / ХУД-12 дугаар хороо 27-р гудамж / |
| 2.2 | 35/6 кВ-ын Шувуу дэд станцаас 6 кВ-ын Бөхөг фидерийн АТП-3518 дэд өртөөний 0,4 кВ-ын зүүн гаргалгын төгсгөлийн тулгуураас бүрээстэй агаарын шугам татаж айл өрхүүдийг тэжээх. /ХУД-13 дугаар хороо 4-р хэсэг/ |
| 2.3 | 35/6 кВ-ын Био /шинэ/ дэд станцаас 6 кВ-ын Шувуу-2 фидерийн тулгуур № 148-д хуурай салгуур суурилуулан кабель шугам татаж шинээр баригдах дэд өртөөг тэжээх. 120ЦА ХТП-0174-ийн 0,4 кВ-ын хороо гаргалгаас одоо холбогдсон хэрэглэгчдийг шинээр баригдах дэд өртөөнд шилжүүлэх холбох. /ХУД-13 дугаар хороо 5а хэсэг/ |
| 2.4 | 35/6 кВ-ын Шувуу дэд станцаас 6 кВ-ын Бөхөг фидерийн АТП-776 дэд өртөөний 0,4 кВ-ын талд шинээр гаргалга гаргах болон одоо байгаа гаргалгуудаас |

- үргэлжүүлэн бүрээстэй агаарын шугам татаж айл өрхүүдийг тэжээх. /ХУД-13 дугаар хороо 5б-1-р хэсэг/
- 2.5 35/6 кВ-ын Шувуу дэд станцаас 6 кВ-ын Бөхөг фидерийн АТП-0776 дэд өртөөний 0.4 кВ талд шинээр гаргалга гаргах болон одоо байгаа гаргалгуудаас үргэлжүүлэн бүрээстэй агаарын шугам татаж айл өрхүүдийг тэжээх. /ХУД-13 дугаар хороо 5б-2-р хэсэг/
- 2.6 35/6 кВ-ын Шувуу дэд станцаас 6 кВ-ын Бөхөг фидерийн АТП-2440 дэд өртөөний 0.4 кВ талд шинээр гаргалга гаргах болон одоо байгаа гаргалгуудаас үргэлжүүлэн бүрээстэй агаарын шугам татаж айл өрхүүдийг тэжээх. /ХУД-13 дугаар хороо 6-р хэсэг/
- 2.7 35/6 кВ-ын Шувуу дэд станцаас 6 кВ-ын Бөхөг фидерийн тулгуур № 12-д хуурай салгуур суурилуулан кабель шугам татаж шинээр баригдах дэд өртөөг тэжээх. /ХУД-13 дугаар хороо 4б хэсэг/
- 2.8 35/6 кВ-ын Шувуу дэд станцаас 6 кВ-ын Бөхөг фидерийн тулгуур № 252, 244, 273-аас салбарлалт салбар шугамын эхэнд хуурай салгуур суурлиулж бүрээстэй агаарын шугам татаж шинээр баригдах дэд өртөөг тэжээх. /ХУД-13 дугаар хороо 7-р хэсгийн шинэ суурьшлийн бүс/

Гурав. Тоолуур, хэмжих хэрэгсэл:

- 3.1 Монгол Улсын Засгийн газрын тохируулагч агентлаг-Стандарт, хэмжилзүйн газрын загварын туршилт орон, ашиглахыг зөвшөөрч, баталгаажуулсан байх.
- 3.2 Дэд өртөөний 0.4 кВ талын ерөнхий оруулгуудад УБЦТС ТӨХК-д ашиглагдаж байгаа ухаалаг тоолуурын системд холбогдон ажилладаг, DLMS протоколыг дэмждэг, 4G модемтой, тасалж залгах команд өгөх боломжтой, 3 фазын ухаалаг тоолуур, гүйдлийн трансформаторыг тусгай хайрцагт суурилуулах.
- 3.3 Шинээр нэмэгдсэн айл ерхөд 1 фазын баталгаат бүрэн электрон тоолуур, ачаалалд тохирсон дифференциал автомат, хамгаалан таслах төхөөрөмж /УЗО/ суурилуулах. Тоолууруудыг батлагдсан зургийн дагуу нэгдсэн шитэнд байршуулах

Дөрөв. Тусгай заалтууд:

- 4.1 Тус техникийн нөхцөлд тусгагдсан байршлуудад олон улсын стандартын шаардлага хангасан, алдагдал багатай 400 кВА чадалтай, 6, 10 кВ-ын хүчдлийн түвшинд шилжин ажиллах боломжтой 6, 10/0.4 кВ-ын хүчдлийн, хүчдэл тохируулгын 5 шатлалтай трансформатор бүхий дэд өртөөг /КТПН/ шинээр барих.
- 4.2 Энэхүү техникийн нөхцөл нь дараах нөхцөл, шаардлагуудыг хангасан тохиолдолд хүчинтэй болно
- 4.2.1) Энэхүү техникийн нөхцөлийн хүчинтэй байх хугацаанд түгээх сүлжээнд холбогдсон байх шаардлагатай.
- 4.2.2) Эх үүсвэр дэд станц, шугам тоноглол хэт ачаалагдсан тул түгээх сүлжээнд 2023, 2024 онд цахилгаан ачаалал нэмэх боломжгүй. Шугам сүлжээнээс 2025 онд 100 кВА чадлаас хэтрэхгүйгээр хангана.
- 4.2.3) Цаашид эх үүсвэр дэд станц, шугам тоноглолын хүчин чадлыг нэмэгдүүлж өргөтгөл шинэчлэлийн ажил хийгдсэний дараа олгосон бүрэн чадлыг үе шаттайгаар ашиглах боломжтой юм.
- 4.3 Шинээр баригдах КТПН дэд өртөөний гадна талаар хамгаалалтын торон хашаа, цацруулагчийг ажлын зураг төслийн дагуу хийх.
- 4.4 Өвлийн их ачааллын горимд тус цахилгаан ачааллыг залгах боломжгүй тул жил

- бүрийн 11-р сарын 01-ээс 03-р сарын 01 хүртэл ахуйн хэрэглээнээс бусад цахилгаан ачааллыг нэгдсэн системийн зохицуулалтаар хязгаарлах арга хэмжээ авах нөхцөлөөр энэхүү техникийн нөхцөлийг олгов.
- 4.5 УБЦТС ТӨХК-ийн эзэмшлийн дэд станц, шугам тоноглолд хийгдэх өргөтгөл, шинэчлэлийн ажлыг харьяа түгээх төвөөр гүйцэтгүүлэх.
- 4.6 Шинээр баригдах дэд өртөөний 0.4 кВ талаас батлагдсан зураг төслийн дагуу бүрээстэй агаарын шугам болон кабель шугам татаж одоо ашиглагдаж байгаа дэд өртөөний 0.4 кВ-ын шугамтай холбох.
- 4.7 Дэд өртөөний ачааллыг шилжүүлж байгаатай холбогдуулан одоо ашиглагдаж байгаа 0.4 кВ-ын агаарын шугамд зохих өөрчлөлтийг батлагдсан зураг төслийн дагуу хийх
- 4.8 Шинээр барих цахилгаан дамжуулах шугамын эхэнд богино залгааны гэмтэл заагч датчикийг суурилуулах. Техникийн шаардлагын тодорхойлолтыг www.tog.mn хаягаар орж хууль, эрх зүйн акт хавтасны баримт бичиг цонхноос үзэх.
- 4.9 Дэд станц, шугам тоноглол нь хоёр талын цахилгааны эх үүсвэрээс тэжээлтэй болон автомат сэлгэн залгагч төхөөрөмж суурилуулсан мөн аваарийн нөөц тэжээлийн эх үүсвэр /дизель, генератор/-тэй бол харьяа түгээх төвтэй Шуурхай ажиллагааны гэрээ байгуулах.
- 4.10 Техникийн нөхцөлийн дагуу шинээр суурилуулах тоноглолууд нь өмнө ашиглагдаж байгаагүй шинэ байх, кабель шугам, трансформаторууд нь сүүлийн үеийн байгаль орчинд ээлтэй, дэвшилтэд техник технологи бүхий байх. Нэгдсэн сүлжээний дүрэмд заасны дагуу $\pm 10\%$ -ийн хүчдлийн хэлбэлзэлд хэвийн ажиллах.
- 4.11 Шугам, дэд станцын гүйцэтгэлийн зургийг гаргаж, ашиглагч байгууллага УБЦТС ТӨХК-д хүлээлгэн өгөх, гүйцэтгэлийн зургийг гаргахдаа кабель шугамын холболтын муфтуудыг заасан, бусад инженерийн шугам сүлжээ, авто замтай огтлолцсон хэсгийн зүсэлтийг тусгах.
- 4.12 Дэд өртөөний бүх тоноглол, гаргалга кабель шугамууд болон агаарын шугамын тулгуур бүрт НСД, ААД, ТАД-д заагдсаны дагуу хаягжилт, плакатжуулах ажлыг гүйцэтгэсэн байна.
- 4.13 Хэрэглэгчид очих эрчим хүчний чанар, стандартын шаардлага хангахгүй тохиолдолд хүчдэл өргөх болон техникийн нэмэлт арга хэмжээнүүдийг хангагч байгууллагатай хамтарсан хэмжилт туршилтын үндсэн дээр хэрэгжүүлнэ. Гарах зардлыг хэрэглэгч бүрэн хариуцна.
- 4.14 Барилга угсралтын ажлын зураг нь ЦБД, ТАД, ААД, ЭХ-ний шугам сүлжээг хамгаалах дүрэм, ЭХ хэрэглэх дүрэм болон УБЦТС ТӨХК-аас хэрэгжүүлж байгаа ашиглалт борлуулалтын арга хэмжээний шаардлагуудыг хангасан байна.
- 4.15 Өөрийн дэд станц, шугам тоноглолоос хангагчийн зөвшөөрөлгүйгээр бусад хэрэглэгчийг холбосон тохиолдолд цахилгаан хангамж, хэрэглээг түдгэлзүүлнэ.
- 4.16 Гадны эзэмшлийн шугам тоноглолоос холбогдох тохиолдолд зураг төсөл боловсруулах шатанд эзэмшигчээс зөвшөөрөл авч, зөвшилцсөн байх.
- 4.17 Өвлийн их ачааллын улиралд эрчим хүчний системийн горим ажиллагааг хангах үүднээс урьдчилан мэдэгдэлгүйгээр хязгаарлалт хийж болзошгүй тул нөөц эх үүсгүүрийг бэлэн байдлыг хангаж ажиллахыг анхаарна уу.
- 4.18 Шинээр баригдах цахилгаан дамжуулах кабель шугам нь:
- 4.18.1) Шинээр татах 10 кВ-ын кабель шугам нь MNS 6819:2015 стандартын шаардлагыг хангасан байх.
- 4.18.2) Шинээр татах 10 кВ-ын кабель шугамын хөндлөн огтлолыг хэрэглээ

ачаалалтай уялдуулан зураг төслийн шатанд тооцоогоор сонгох, ашиглагч "УБЦТС" ТӨХК-тай зөвшилцөх.

4.18.3) Кабелиуд нь 10 кВ-ын хүчдлийн түвшинд ашиглах, орчны температур -15 хэм байхад угсралт хийх боломжтой байх.

4.19 Шинээр баригдах цахилгаан дамжуулах агаарын шугам нь:

4.19.1) Цахилгаан дамжуулах агаарын шугамын үндсэн хийц болох анкер болон завсрын тулгуур нь төмөр болон төмөр бетон байх

4.19.2) Дамжуулагч нь бүрээстэй байх ба хөндлөн огтлолыг ачаалалтай уялдуулан, тооцоогоор сонгох, мөн утасны механик ачаалалд тохирсон үндсэн хийцүүд, хөндийрүүлэгч элементүүдийг тооцоогоор сонгох

4.19.3) Цахилгаан дамжуулах агаарын шугамын үндсэн хийцүүд, дамжуулагч утас, хөндийрүүлэгч элементүүд, утас угсралтын тоног төхөөрөмжүүд нь Монгол улсын стандартын шаардлага хангасан байх, тухайн газрын байгаль цаг уур, газарзүйн онцлогийг харгалзан зураг төслөөр сонгох.

4.20 Шинээр барих КТПН-н салбар авч байгаа тулгуурууд нь бетон хөлтэй модон тулгуур байвал батлагдсан зургийн дагуу төмөр бетон тулгуураар шинэчлэн сольж, УБЦТС ТӨХК-ийн үндсэн хөрөнгөнд бүртгүүлэн, харьяа түгээх төвд актаар хүлээлгэн өгөх

4.21 Тухайн байршилд одоо байгаа дэд өртөөний ачааллыг шилжүүлэхдээ харьяа түгээх төв болон хэрэглэгчдэд үйлчлэх төвөөр хяналт тавиулан шинээр баригдсан дэд өртөөний 0.4 кВ-ын гаргалга шугамд шилжүүлэх

4.22 Дэд өртөөнүүдийн 0.4 кВ-ын агаарын шугамын уулзвар цэгт рубильник суурилуулах. Техникийн тодорхойлолтыг Техникийн бодлого зохицуулалтын хэлтсээс авах.

4.23 Энэхүү техникийн нөхцөлийн дагуу КТПН-6321, АТП-3518, АТП-0776, АТП-2440 дэд өртөөнүүдийн трансформаторуудын чадлыг олон улсын стандартын шаардлага хангасан, алдагдал багатай 400 кВА чадалтай, 6, 10 кВ-ын хүчдлийн түвшинд шилжин ажиллах боломжтой 6, 10/0.4 кВ-ын хүчдлийн, хүчдэл тохируулгын 5 шатлалтай трансформатороор томсгон солих.

4.23.1) Дэд өртөөнүүдийн трансформаторын хүчин чадал нэмэгдүүлж байгаатай холбогдуулан дэд станцын 0.4 кВ болон 6 кВ талд зохих өөрчлөлтүүдийн хийх.

4.24 Буусан трансформатор болон шугам тоног төхөөрөмжийг Монгол улсын засгийн газрын 2001 оны 263-р тогтоолын 2.6.3-т заасны дагуу УБЦТС ТӨХК-ийн үндсэн хөрөнгөнд шилжүүлэн өгөх.

Тав. Дор дурдсан техникийн даалгавар, хууль дүрмийг мөрдөх:

5.1 Шугам, дэд өртөөний "Ажлын зураг төсөл"-ийг тухайн нутаг дэвсгэрийн ерөнхий төлөвлөгөө хариуцсан нэгж болон бусад шаардлагатай байгууллагуудтай зөвшилцөн, мэдээллийн санд оруулсан байх, схем холболт, хүчин чадлыг тус компаниар хянуулах.

5.2 Энэхүү техникийн нөхцөлийн дагуу тавигдах шугам, тоноглолууд нь өмнө нь ашиглагдаж байгаагүй шинэ байх ба Улаанбаатар цахилгаан түгээх сүлжээ төрийн өмчит хувьцаат компанийн баталсан "Техникийн шаардлагын тодорхойлолт"-ыг хангасан байх шаардлагатай. Техникийн шаардлагын тодорхойлолтыг www.tog.mn хаягаар орж хууль, эрх зүйн акт хавтасны баримт бичиг цонхноос үзэх.

5.3 Цахилгаан шугам сүлжээнд холбогдох явцад дайрч гарах зам талбай, бут сөөгийг сэргээн засварлах.

- 5.4 Засгийн газрын 2020 оны 97 тоот тогтоолоор батлагдсан "Цахилгаан эрчим хүч хэрэглэх дүрэм"-ийн заалтуудыг мөрдлөг болгох.
- 5.5 "Эрчим хүчний тухай" хуулийн 29.1.9, 30.1.10-ийн дагуу өөрийн тоноглолоос тус компанийн зөвшөөрлөөр шинээр хэрэглэгч нэмж холбуулах.
- 5.6 "Эрчим хүчний тухай" хуулийн 30.1.8 "Өөрийн эзэмшлийн шугам, сүлжээ, тоног төхөөрөмжийн бүрэн бүтэн, аюулгүй байдал, засвар үйлчилгээ, баталгаажуулалтыг бүрэн хариуцах" гэж заасны дагуу өөрийн ашиглалт үйлчилгээний зааг доторхи цахилгаан тоног төхөөрөмжиндөө байнгын үзлэг шалгалт хийх, хэвийн бус ажиллагаатай үед өөрсдийн хөрөнгөөр засвар үйлчилгээг хийлгэх.
- 5.7 Түгээх сүлжээнд залгагдах болон залгаатай байгаа хувийн шугам тоноглол эзэмшигч нь өөрийн шугамын урт, тоноглолын хүчин чадлаас хамааруулан тус компанийн харьяа түгээх төвтэй шуурхай ажиллагааны гэрээг байгуулах.
- 5.8 Хэрэглэгч нь техникийн нөхцөлийн дагуу захиалсан чадлаа бүрэн ашиглаж чадаагүй нь цахилгаан эрчим хүчний хэрэглээгээр нотлогдсон бол олгогдсон чадлын хэмжээг бууруулж дахин техникийн нөхцөл олгоно.
- 5.9 "Эрчим хүчний тухай" хуулийн 33 дугаар зүйлд заасны дагуу шугам сүлжээний хамгаалалтын зурвас дотор гэр, орон сууц, барилга байгууламж барих, шугам сүлжээ өмчлөгч, эзэмшигчийн зөвшөөрснөөс бусад үйл ажиллагаа явуулахыг хориглоно.
- 5.10 Дэд өртөө, цитний газардуулга болон шугам тоноглолын хэмжилт, туршилтыг норм, дүрмийн дагуу хийлгэн холбогдох газраар шалгуулж протокол авсан байх.
- 5.11 Угсралтын ажлын явцад тус компанийн харьяа түгээх төвөөр хяналт тавиулж, холбогдох баримтыг бүрдүүлсэн байх.
- 5.12 Цахилгаан угсралтын ажлыг тусгай зөвшөөрөлтэй эрх бүхий байгууллагаар Аюулгүй ажиллагааны дүрэм, Техник ашиглалтын дүрэм, Цахилгаан байгууламжийн дүрмийн дагуу гүйцэтгүүлэх.
- 5.13 Цахилгаан эрчим хүчний тооцоог Улаанбаатар цахилгаан түгээх сүлжээ төрийн өмчит хувьцаат компанийн харьяа хэрэглэгчдэд үйлчлэх төвтэй хийх.

Зургаа. Бусад:

- 6.1 Монгол Улсын Засгийн газрын 2020 оны 03 дугаар сарын 18-ны өдрийн 97 дугаар тогтоолын хавсралтаар батлагдсан "Цахилгаан эрчим хүч хэрэглэх дүрэм"-ийн 2.17-д заасан доорх заалтуудыг мөрдлөг болгоно. Дараах тохиолдолд олгосон техникийн нөхцөлийг хүчингүйд тооцно. Үүнд:
- 6.1.1) Техникийн нөхцөл авахдаа шаардлагатай өгөгдлүүдийг буруу тодорхойлсон, баримт бичгийг хуурамчаар үйлдсэн тохиолдолд.
- 6.1.2) Холболт хийх цэгийн хүчин чадлаас хэтрүүлэн техникийн нөхцөл олгосон.
- 6.1.3) Техникийн нөхцлийн хүчинтэй байх хугацаанд цахилгааны сүлжээнд холбогдоогүй тохиолдолд.
- 6.1.4) Хугацаа дууссан техникийн нөхцөлөөр зураг төсөл боловсруулах, барилга байгууламж барихыг хориглоно.
- 6.1.5) Техникийн нөхцөлийн хүчинтэй хугацаа дуусахаас 2 сарын өмнө сунгуулах хүсэлтээ гаргана. Хугацаа дууссан техникийн нөхцөлийг хүчингүй тооцно.
- 6.1.6) Техникийн нөхцөлийн олгосон чадлаас хэтрүүлэн чадал ашигласан тохиолдолд.
- 6.2 Монгол Улсын Засгийн газрын 2020 оны 03 дугаар сарын 18-ны өдрийн 97 дугаар

тогтоолын хавсралтаар батлагдсан "Цахилгаан эрчим хүч хэрэглэх дүрэм"-ийн 2.9-д заасны дагуу 1 жилийн хугацаанд хүчинтэй байна.

6.3

Техникийн нөхцөлийн хугацааг сунгуулах тохиолдолд Монгол Улсын Засгийн газрын 2020 оны 03 дугаар сарын 18-ны өдрийн 97 дугаар тогтоолын хавсралтаар батлагдсан "Цахилгаан эрчим хүч хэрэглэх дүрэм"-ийн 2.13, 2.16-д заасны дагуу зураг төслийг боловсруулан баталгаажуулсан байна.





ТЕХНИКИЙН НӨХЦӨЛ

Дугаар 16/05354/21

2021 оны 10 сарын 29 өдөр

Улаанбаатар хот

Нэг. Ерөнхий мэдээлэл:

1.1	Хүсэлтийн дугаар:	21-99-002187
1.2	Хэрэглэгчийн нэр, регистр:	ХАН-УУЛ ДҮҮРГИЙН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗАР Төрийн байгууллага - РД: 9120335,
1.3	Хэрэглэгчийн байршил:	Улаанбаатар Хан-Уул 13-р хороо, - Хан-Уул дүүргийн 13-р хороо 4, (5а), 5б-1, 5б-2) 6-р хэсгүүдийн айл өрхийн хүчдэлийн алдагдал бууруулах, (4б) 7-р хэсгүүдийн шинэ суурьшлын бүсэд эрчим хүч татах, Хан-Уул дүүргийн 14-р хороо Хар хошуу хэсгийн айл өрхийн хүчдэлийн алдагдал бууруулах шинэ эрчим хүч татах, Хан-Уул дүүргийн 12-р хороо Сонгино-27 хэсэгт
1.4	Ажил үйлчилгээний зориулалт:	Инженерийн байгууламж
1.5	Техникийн нөхцөл олгох үндэслэл:	1) Хан-Уул дүүргийн засаг даргын 2021-09-10-ны №06/1192 дугаар албан хүсэлт. 2) Хан-Уул дүүргийн 13, 14 дүгээр хорооны цахилгааны хүчдэл сайжруулах ажлын зураг төсөл боловсруулах
1.6	Техникийн нөхцөлийн ангилал:	Шинэ холболт
1.7	Тооцооны бүрэн чадал:	400 кВА /Дөрвөн зуу/ (тоогоор) (үсгээр)

Хоёр. Холболтын цэг:

2.1	35/6 кВ-ын Био /хуучин/ дэд станцаас 6 кВ-ын Био-1 фидерийн КТПН-6321 дэд өртөөний 0,4 кВ талаас шинээр гаргалга гаргаж бүрээстэй агаарын шугам татаж АТП-5163, АТП-1681 дэд өртөөнүүдийн ачаалал хөнгөлөх. / ХУД-12 дугаар хороо 27-р гудамж /
2.2	35/6 кВ-ын Шувуу дэд станцаас 6 кВ-ын Бөхөг фидерийн АТП-3518 дэд өртөөний 0,4 кВ-ын зүүн гаргалгын төгсгөлийн тулгуураас бүрээстэй агаарын шугам татаж айл өрхүүдийг тэжээх. /ХУД-13 дугаар хороо 4-р хэсэг/
2.3	35/6 кВ-ын Био /шинэ/ дэд станцаас 6 кВ-ын Шувуу-2 фидерийн тулгуур № 148-д хуурай салгуур суурилуулан кабель шугам татаж шинээр баригдах дэд өртөөг тэжээх. 120ЦА ХТП-0174-ийн 0,4 кВ-ын хороо гаргалгаас одоо холбогдсон хэрэглэгчдийг шинээр баригдах дэд өртөөнд шилжүүлэх холбох /ХУД-13 дугаар хороо 5а хэсэг/
2.4	35/6 кВ-ын Шувуу дэд станцаас 6 кВ-ын Бөхөг фидерийн АТП-776 дэд өртөөний 0,4 кВ-ын талд шинээр гаргалга гаргах болон одоо байгаа гаргалгуудаас үргэлжүүлэн бүрээстэй агаарын шугам татаж айл өрхүүдийг тэжээх. /ХУД-13 дугаар хороо 5б-1-р хэсэг/

ТӨХИЙН АРХИВ
ХУУЛБАР
2021 оны 10 сарын 30-ний өдөр

- АТН-776
-
- 2.5 35/6 кВ-ын Шувуу дэд станцаас 6 кВ-ын Бөхөг фидерийн КТДН-6127 дэд өртөөний 0,4 кВ талд шинээр гаргалга гаргах болон одоо байгаа гаргалгуудаас үргэлжүүлэн бүрээстэй агаарын шугам татаж айл өрхүүдийг тэжээх. / ХУД-13 дугаар хороо 56-2-р хэсэг/
- 2.6 35/6 кВ-ын Шувуу дэд станцаас 6 кВ-ын Бөхөг фидерийн АТН-2440 дэд өртөөний 0,4 кВ талд шинээр гаргалга гаргах болон одоо байгаа гаргалгуудаас үргэлжүүлэн бүрээстэй агаарын шугам татаж айл өрхүүдийг тэжээх. / ХУД-13 дугаар хороо 6-р хэсэг/
- 2.7 35/6 кВ-ын Шувуу дэд станцаас 6 кВ-ын Бөхөг фидерийн тулгуур № 12-д хуурай салгуур суурилуулан кабель шугам татаж шинээр баригдах дэд өртөөг тэжээх. / ХУД-13 дугаар хороо 4б хэсэг/
- 2.8 35/6 кВ-ын Шувуу дэд станцаас 6 кВ-ын Бөхөг фидерийн тулгуур № 405, 410, 455 аас салбарлалт салбар шугамын эхэнд хуурай салгуур суурлиулж бүрээстэй агаарын шугам татаж шинээр баригдах дэд өртөөг тэжээх. / ХУД-13 дугаар хороо 7-р хэсгийн шинэ суурьшлийн бүс/
- 2.9 № 252, 244, 273
-

Гурав. Тоолуур, хэмжих хэрэгсэл:

- 3.1 Дэд өртөөний 0,4 кВ талын ерөнхий оруулганд СХЗҮТ-ийн загварын туршилтанд орсон DLMS протоколыг дэмждэг 3 фазын баталгаат, бүрэн электрон тоолуур, ачаалалд тохирсон гүйдлийн трансформаторыг тусгай хайрцагт суурилуулах.
- 3.2 Шинээр нэмэгдсэн айл өрхөд 1 фазын баталгаат бүрэн электрон тоолуур, ачаалалд тохирсон дифференциал автомат, хамгаалан таслах төхөөрөмж /УЗО/ суурилуулах, Тоолууруудыг батлагдсан зургийн дагуу нэгдсэн цитэнд байршуулах

Дөрөв. Тусгай заалтууд:

- 4.1 Тус техникийн нөхцөлд тусгагдсан байршлуудад олон улсын стандартын шаардлага хангасан, алдагдал багатай 400 кВА чадалтай, 6, 10 кВ-ын хүчдлийн түвшинд шилжин ажиллах боломжтой 6, 10/0.4 кВ-ын хүчдлийн, хүчдэл тохируулгын 5 шатлалтай трансформатор бүхий дэд өртөөг / КТПН/ шинээр барих.
- 4.2 Шинээр баригдах КТПН дэд өртөөний гадна талаар хамгаалалтын торон хашаа, цацруулагчийг ажлын зураг төслийн дагуу хийх.
- 4.3 Шинээр баригдах дэд өртөөний 0.4 кВ талаас батлагдсан зураг төслийн дагуу бүрээстэй агаарын шугам болон кабель шугам татаж одоо ашиглагдаж байгаа дэд өртөөний 0.4 кВ-ын шугамтай холбох.
- 4.4 Дэд өртөөний ачааллыг шилжүүлж байгаатай холбогдуулан одоо ашиглагдаж байгаа 0.4 кВ-ын агаарын шугамд зохих өөрчлөлтийг батлагдсан зураг төслийн дагуу хийх
- 4.5 Шинээр барих КТПН-н салбар авч байгаа тулгуурууд нь бетон хөлтэй модон тулгуур байвал батлагдсан зургийн дагуу төмөр бетон тулгуураар шинэчлэн сольж, УБЦТС ТӨХК-ийн үндсэн хөрөнгөнд бүртгүүлэн, харьяа түгээх төвд актаар хүлээлгэн өгөх
- 4.6 Тухайн байршилд одоо байгаа дэд өртөөний ачааллыг шилжүүлэхдээ харьяа түгээх төв болон хэрэглэгчдэд үйлчлэх төвөөр хяналт тавиулан шинээр баригдсан дэд өртөөний 0.4 кВ-ын гаргалга шугамд шилжүүлэх
- 4.7 Дэд өртөөнүүдийн 0.4 кВ-ын агаарын шугамын үүлээр цэгт рубильник суурилуулах. Техникийн тодорхойлолтыг Техникийн бодлого зохицуулалтын
-

- хэлтсээс авах.
- 4.8 Техникийн нөхцөлийн дагуу шинээр суурилуулах тоноглолууд, агаарын болон кабель шугам, трансформаторууд нь сүүлийн үеийн байгаль орчинд ээлтэй, дэвшилтэд техник технологи бүхий байх.
- 4.9 Дэд станцад суурилуулж буй тоноглолууд нь өмнө нь ашиглагдаж байгаагүй шинэ байх, $\pm 10\%$ -ийн хүчдэлийн хэлбэлзэлд хэвийн ажилладаг байх.
- 4.10 Буусан трансформатор болон шугам тоног төхөөрөмжийг Монгол улсын засгийн газрын 2001 оны 263-р тогтоолын 2.6.3-т заасны дагуу УБЦТС ТӨХК-ийн үндсэн хөрөнгөнд шилжүүлэн өгөх.
- 4.11 Энэхүү техникийн нөхцөлийн дагуу КТПН-6321, АТП-3518, АТП-0776, АТП-2440 дэд өртөөнүүдийн трансформаторуудын чадлыг олон улсын стандартын шаардлага хангасан, алдагдал багатай 400 кВА чадалтай, 6, 10 кВ-ын хүчдлийн түвшинд шилжин ажиллах боломжтой 6, 10/0.4 кВ-ын хүчдлийн, хүчдэл тохируулгын 5 шатлалтай трансформатороор томсгон солих.
- 4.11.1) Дэд өртөөнүүдийн трансформаторын хүчин чадал нэмэгдүүлж байгаатай холбогдуулан дэд станцын 0,4 кВ болон 6 кВ талд зохих өөрчлөлтүүдийн хийх.

Тав. Дор дурдсан техникийн даалгавар, хууль дүрмийг мөрдөх:

- 5.1 Шугам, дэд өртөөний "Ажлын зураг төсөл"-ийг тухайн нутаг дэвсгэрийн ерөнхий төлөвлөгөө хариуцсан нэгж болон бусад шаардлагатай байгууллагуудтай зөвшилцөн, мэдээллийн санд оруулсан байх, схем холболт, хүчин чадлыг тус компаниар хянуулах.
- 5.2 Энэхүү техникийн нөхцөлийн дагуу тавигдах шугам, тоноглолууд нь өмнө нь ашиглагдаж байгаагүй шинэ байх ба Улаанбаатар цахилгаан түгээх сүлжээ төрийн өмчит хувьцаат компанийн баталсан "Техникийн шаардлагын тодорхойлолт"-ыг хангасан байх шаардлагатай. Техникийн шаардлагын тодорхойлолтыг www.tog.mn хаягаар орж хууль, дүрэм цонхноос үзэх.
- 5.3 Цахилгаан шугам сүлжээнд холбогдох явцад дайрч гарах зам талбай, бут сөөгийг сэргээн засварлах.
- 5.4 Засгийн газрын 2020 оны 97 тоот тогтоолоор батлагдсан "Цахилгаан эрчим хүч хэрэглэх дүрэм"-ийн заалтуудыг мөрдлөг болгох.
- 5.5 "Эрчим хүчний тухай" хуулийн 29.1.9, 30.1.10-ийн дагуу өөрийн тоноглолоос тус компанийн зөвшөөрлөөр шинээр хэрэглэгч нэмж холбуулах.
- 5.6 "Эрчим хүчний тухай" хуулийн 33 дугаар зүйлд заасны дагуу шугам сүлжээний хамгаалалтын зурвас дотор гэр, орон сууц, барилга байгууламж барих, шугам сүлжээ өмчлөгч, эзэмшигчийн зөвшөөрснөөс бусад үйл ажиллагаа явуулахыг хориглоно.
- 5.7 Дэд өртөө, щитний газардуулга болон шугам тоноглолын хэмжилт, туршилтыг норм, дүрмийн дагуу хийлгэн холбогдох газраар шалгуулж протокол авсан байх.
- 5.8 Угсралтын ажлын явцад тус компанийн харьяа түгээх төвөөр хяналт тавиулж, холбогдох баримтыг бүрдүүлсэн байх.
- 5.9 Цахилгаан угсралтын ажлыг тусгай зөвшөөрөлтэй эрх бүхий байгууллагаар Аюулгүй ажиллагааны дүрэм, Техник ашиглалтын дүрэм, Цахилгаан байгууламжийн дүрмийн дагуу гүйцэтгүүлэх.
- 5.10 Цахилгаан эрчим хүчний тооцоог Улаанбаатар цахилгаан түгээх сүлжээ төрийн өмчит хувьцаат компанийн харьяа хэрэглэгчдэд үйлчлэх тавтай хийх.

Зургаа. Бусад:

Бүртгэлийн дугаар ... 2879





ХУУЛБАР ҮНЭН

Хуулбар олгосон амжилтын гарим үсэг


25/8 30

6.1	Энэхүү техникийн нөхцөлийн дагуу холболтыг 2 жилийн хугацаанд хийж гүйцэтгэх бөгөөд энэ хугацаанд цахилгаан сүлжээнд холбогдоогүй тохиолдолд шинээр техникийн нөхцөл авна.
-----	--

Комиссын гишүүд:

 Л.Ганзориг
 Б.Аззаяа
 Т.Мөнхболд
 Н.Пунцагноров
 С.Батжаргал

Боловсруулсан:



“УЛААНБААТАР ЦАХИЛГААН ТҮГЭЭХ СҮЛЖЭЭ” ТӨХК-ИЙН АШИГЛАЛТ,
ЗАСВАРЫН БАРУУН ТӨВ ЗУРАГ ТӨСӨЛД ТОДРУУЛГА ХИЙСЭН
ТОДОРХОЙЛОЛТ

2023 оны 08 сарын 17


1. Зураг төслийн захиалагч, объектын байршил: Улаанбаатар хот. Хан-Уул дүүрэг 13-р хорооны 5А хэсгийн айл өрхүүдийн цахилгааны хүчдэл сайжруулах ажлын зураг төсөл.

2. Зураг төслийн гүйцэтгэгч: “Оргилт-Од” ХХК

3. Зураг төслийн дугаар, нэр: OD-02/2023


4. Зураг төсөлд хийсэн тодруулга:

А. Ойртож буй шугам, тоноглол **- гадны ашиглалт



Б. Огтлолцож буй шугам, тоноглол

- Төлөвлөж буй 6 кВ-ын ЦДАШ, 6 кВ-ын ЦДКШ, КТПН, 0,4 кВ-ын ЦДАШ, 0,4 кВ-ын ЦДКШ-ын трасст АЗБТ-ийн ашиглалтын шугам тоноглол ойртож, огтлолцоогүй болно.



Ажил эхлэх үед КАЗТ-р хяналт тавиулах, газар дээр нь кабелийн тандалт хийлгэх шаардлагатай

Жич: Бусад иргэн, хуулийн этгээдийн шугам сүлжээг тухайн эзэмшигчтэй зөвшилцөх шаардлагатай.

Тодруулга хийсэн: Мэдээллийн сангийн инженер:  /Э.Ганжаргал/

Цахилгаан дамжуулах кабель шугамын трассын тодруулга хийлгэсэн хэрэглэгчдэд өгөх зөвлөмж

УБЦТС ХК-ийн Ашиглалт Засварын Баруун Төв:

1. Кабель шугамаас 2 тийш 2 метр босоо хавтгайгаар хязгаарлагдах бүсэд машин, механизм хэрэглэхийг хориглоно. Кабель шугамыг КАЗТ-ийн ажилтны хяналтан дор гараар ухаж ил гаргана.
2. Газар доор байгаа хамгийн захын кабель шугамаас 2 тийш 5 метр босоо хавтгайгаар хязгаарлагдах бүсэд цохилтот машин, механизм хэрэглэхийг хориглоно.
3. Кабель шугамын трассыг чагнуулж энэхүү хуудсыг авсанаас хойш 30 хоногт /ГША /-ыг хийгээгүй бол дахин тандалт хийлгэх.
4. Хэмжилт хийж кабель шугамтай гэж тодорхойлсон цэгт кабель шугам илрээгүй тохиолдолд, мөн тусгагдаагүй кабель шугам илэрсэн үед хэмжил хийлгэсэн инженертэй эргэж холбоо барин дахин тодорхойлуулна.
5. Кабель хайгч багажны мэдрэх чадвараас шалтгаалан заасан цэгт дулаан, цэвэр болон бохир усны труба, холбооны кабель шугам гарч болохоос гадна хүчдэлтэй болон хүчдэлгүй кабель шугам аль аль нь хамтдаа мэдрэгдэх тул анхаарах.
6. Санамсаргүй тохиолдлоор кабель шугамыг ил гаргасан буюу гэмтээсэн тохиолдолд кабель шугамыг тодорхойлон яаралтай холбоо барих.
7. Газар шорооны ажил хийж байхдаа кабель шугамыг гэмтээсэн тохиолдолд тухайн кабель гэмтээд зогсохгүй бусад тоног төхөөрөмж гэмтэх, хэрэглэгчдийн цахилгаан хэрэгсэл шатах зэрэг ноцтой зөрчилүүд үүсэх бөгөөд гарсан төлбөрийг буруутай байгууллага, ААН, иргэн хариуцна.
8. Гадны ашиглалтын шугам сүлжээг / Авто замын гэрэлтүүлэг, Цахилгаан тээвэр компани, Улаанбаатар төмөр / ашиглагч байгууллагаас тодруулга авах.
9. Кабелийн тандалт хийсэн талбайд тодорхойлогдоогүй ЦДКШ гарч ирвэл газар шорооны ажлыг зогсоож ашиглагч байгууллагатай зөвшилцөж шийдвэр гарсны дараа ГША-ыг үргэлжлүүлнэ.

Газар шорооны ажил гүйцэтгэх үед өгсөн зөвлөмжийн дагуу ажиллана уу. Бидэнтэй хамтран ажилласан танд баярлалаа.

ЗУРАГ ТӨСӨЛД ТОДРУУЛГА ХИЙСЭН ТОДОРХОЙЛОЛТ

№4/151

УБЦТС ТӨХК: КАЗ Төв.

2023 оны 08 сарын 28

Зураг төслийн захиалагч, объектийн байршил: ХУД 13-р хороо

Зураг төсөлд хийсэн тодруулга: КАЗТ

Зураг төслийн гүйцэтгэгч: Оргилт-Од ХХК

Зураг төслийн дугаар нэр: OD-07-01/2023 13-р хороо 5А-р хэсгийн айл өрхүүдийн цахилгаан хүчдэл сайжруулах

А. Огтлолцож буй шугам, тоноглол



тус тус огтолж, давхцаж байна. “УБЦТС ТӨХК” **Техникийн бодлого шинэчлэлтийн хэлтэстэй** зөвшилцөн холбогдох зөвшөөрлийг авсаны дараа газар шорооны ажлыг гүйцэтгэх. Аливаа **ГАЗАР ШОРООНЫ АЖЛЫГ** эхлэхээс өмнө **КАБЕЛЬ АШИГЛАЛТ ЗАСВАРЫН ТӨВӨӨР** газар дээр нь дахин тодруулга хийлгэн хяналтанд ажлыг гүйцэтгэх шаардлагатайг анхаар !!!.


Хянасан: АҮХ-н ахлагч

/Б.Алтанцэцэг/

Тодруулга хийсэн:

Мэдээллийн сангийн инженер

/Н.Дэлгэрхангай /



Цахилгаан дамжуулах кабель шугамын трассын тодруулга хийлгэсэн хэрэглэгчдэд өгөх зөвлөмж

- Кабель шугамаас 2 тийш 2м босоо хавтгайгаар хязгаарлагдах бүсэд машин, механизм хэрэглэхийг хориглоно. Кабель шугамыг КАЗТ-ийн ажилтны хяналтан дор гараар ухаж ил гаргана.
- Газар доор байгаа хамгийн захын кабель шугамаас 2 тийш 5м босоо хавтгайгаар хязгаарлагдах бүсэд цохилтот машин, механизм хэрэглэхийг хориглоно.
- Кабель шугамын трассыг чагнуулж энэхүү хуудсыг авсанаас хойш 30 хоногт газар шорооны ажил хийгээгүй бол дахин тандалт хийлгэх
- Хэмжилт хийж кабель шугамтай гэж тодорхойлсон цэгт кабель шугам илрээгүй тохиолдолд, мөн тусгагдаагүй кабель шугам илэрсэн үед хэмжилт хийлгэсэн инженертэй эргэж холбоо барин дахин тодорхойлуулна.
- Кабель хайгч багажны мэдрэх чадвараас шалтгаалан заасан цэгт дулаан, цэвэр болон бохир усны труба, холбооны кабель шугам гарч болохоос гадна хүчдэлтэй болон хүчдэлгүй кабель шугам аль аль нь хамтдаа мэдрэгдэх тул анхаарах
- Санамсаргүй тохиолдлоор кабель шугамыг ил гаргасан буюу гэмтээсэн тохиолдолд кабель шугамыг тодорхойлсон инженертэй нэн яаралтай холбоо барих
- Газар шорооны ажил хийж байхдаа кабель шугамыг ил гаргасан буюу гэмтээсэн тохиолдолд кабель шугамыг тодорхойлсон ажилтантай нэн яаралтай холбоо барих
- Газар шорооны ажил хийж байхдаа кабель шугамыг гэмтээсэн тохиолдолд тухайн кабель гэмтээд зогсохгүй бусад тоног төхөөрөмж гэмтэх, хэрэглэгчдийн цахилгаан хэрэгсэл шатах зэрэг ноцтой зөрчилүүд үүсэх бөгөөд гарсан төлбөрийг буруутай байгууллага ААНэгж, иргэн хариуцна.
- Гадны ашиглалтын шугам сүлжээг / Авто замын гэрэл, цахилгаан тээвэр компани, Улаанбаатар төмөр зам / ашиглагч байгууллагаас авах
- Кабелийн тандалт хийсэн талбайд тодорхойлогдоогүй ЦДКШ гарч ирвэл ГША-ыг зогсоож ашиглагч байгууллагатай зөвшилцөж шийдвэр гарсны дараа ГША-г үргэлжлүүлнэ.

ГАЗАР ШОРООНЫ АЖИЛ ГҮЙЦЭТГЭХ ҮЕД ӨГСӨН ЗӨВЛӨМЖИЙН ДАГУУ АЖИЛЛАНА УУ!!! БИДЭРТЭЙ ХАМТРАН АЖИЛЛАСАН ТАНД БАЯРЛАЛАА

БАТЛАВ
ХАН-УУЛ ДҮҮРГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ТАМГЫН ГАЗАР ДАРГЫН АЛБАН
ҮҮРГИЙГ ТҮР ӨРЛӨН ГҮЙЦЭТГЭГЧ

О.ЭНХБАЯР

2021 оны 09 дүгээр сарын 09 өдөр

ХАН-УУЛ ДҮҮРГИЙН 13, 14 ДҮГЭЭР ХОРООНЫ ЦАХИЛГААНЫ ХҮЧДЭЛ САЙЖРУУЛАХ
АЖЛЫН ЗУРАГ ТӨСӨВ БОЛОВСРУУЛАХ ДААЛГАВАР

2021 оны 09 дүгээр сарын 09-ний өдөр

Улаанбаатар хот

№	Төсөл боловсруулах үндэслэл	
1	Байршил, эдэлбэр газрын хэмжээ	<ul style="list-style-type: none">- Хан-Уул дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2020 оны 12-р сарын 11-ний 11 дүгээр тогтоол- Хан-Уул дүүргийн 13-р хороо 4, 5а, 5б-1, 5б-2, 6-р хэсгүүдийн айл өрхийн хүчдэлийн алдагдал бууруулах, 4б, 7-р хэсгүүдийн шинэ суурьшлын бүсэд эрчим хүч татах.- Хан-Уул дүүргийн 14-р хороо Хар хошуу хэсгийн айл өрхийн хүчдэлийн алдагдал бууруулах шинэ эрчим хүч татах
2	Зориулалт хүчин чадал	<ul style="list-style-type: none">- Цахилгааны хүчдэл сайжруулах
3	Одоогийн байдал	<ul style="list-style-type: none">- Цахилгааны хүчдэлийн уналттай,- Цахилгаан дамжуулах агаарын шугамгүй
4	Төсөл гүйцэтгэх хугацаа	<ul style="list-style-type: none">- Захиалагч гүйцэтгэгч талуудын хооронд байгуулсан гэрээнд заасан хугацааг үндэслэл болгоно
5	Төслийн захиалагч	<ul style="list-style-type: none">- Хан-Уул дүүргийн Засаг даргын Тамгын газар
6	Төсөл гүйцэтгэх байгууллага	<ul style="list-style-type: none">- Эрчим хүчний яамнаас олгогддог 03.2.1-03.2.5 хүртэлх аль нэг заалттай байх, 0.4-35 кв-ын цахилгаан дамжуулах шугам дэд станцын ТЭЗҮ, зураг төсөл боловсруулах зөвшөөрөлтэй байх- Барилга хот байгуулалтын яамнаас олгогддог Цахилгаан дамжуулах гол шугам түүнтэй холбогдох барилга байгуулах технологийн зураг боловсруулах тусгай зөвшөөрөл
7	Төсөл боловсруулах үе шат	<ul style="list-style-type: none">- Талбайн судалгаа хийх- Холбогдох техникийн нөхцөл авах /УБЦТ ТӨХК-с/- Ажлын зураг төсөв боловсруулж батлуулах /Магадлал хийлгэсэн байх/
8	Архитектор орон зайн төлөвлөлтөд тавигдах шаардлага	<ul style="list-style-type: none">- Нийтийн эзэмшлийн тохижилт ногоон байгууламж сүйдлэхгүй байх- Авто зам, шугам сүлжээний хамгаалалтын зурвасыг тогтоох- Хот төлөвлөлтийн шаардлагад нийцүүлэн хүчин чадлыг нарийвчлан тогтоох
9	Инженерийн дэд бүтцэд тавигдах шаардлага	<ul style="list-style-type: none">- Ойролцоох шугам сүлжээний аюулгүйн зайн стандартыг мөрдөж ажиллах

		<ul style="list-style-type: none"> - Техникийн нөхцөлд тавигдсан шаардлагын дагуу олон улсын чанарын стандарт хангасан тоног төхөөрөмж кабел материалыг сонгох - Цахилгаан хангамжийн шугаманд одоо холбогдож байгаа хэрэглэгч ба хэтийн төлөвлөлтөөр хэрэглэгчдийг холбох боломжийг бүрдүүлэх - Төвлөрсөн цахилгаан хангамжийн шугам сүлжээнээс хангагдах
10	Төсөл боловсруулахад ашиглах материал	<p>Монгол Улсын хуулиуд</p> <ul style="list-style-type: none"> - Хот байгуулалтын тухай хууль - Барилгын тухай хууль - Эрчим хүчний тухай хууль - Бусад холбогдох хууль <p>Норм, нормативууд:</p> <ul style="list-style-type: none"> - Цахилгаан тоног төхөөрөмжийн байгууламжийн дүрэм БД 43.101.03 - Хот, тосгоны төлөвлөлт, барилгажилтын норм ба дүрэм (БНБд30-01-04) - Барилгын орчны тохижилтын ажлын норм ба дүрэм (БНБд 3.01-06-90) - Барилга байгууламжийн зураг төсөл боловсруулах, зөвшилцөх, магадлал хийх дүрэм - Бусад холбогдох норм, дүрэм
11	Төслийн иж бүрдэл	<p>Баримт бичгийн бүрдэл:</p> <ul style="list-style-type: none"> - Одоогийн байдлын судалгаа - Тайлбар бичиг - Зураг төсөв /магадлал хийгдсэн байх/ <p>Зургийн иж бүрдэл:</p> <ul style="list-style-type: none"> - Нүүр хуудас (батлагдах) - Зураг төсвийн баримт бичиг, Захиалагчид CD-ний хамт 2 хувийг өгөх - Байршлын схем M:2000 - Ерөнхий төлөвлөгөө M1:500-1000 (батлагдах) - Зай хэмжээ M1:200-500 - Зураг төслийг хот байгуулалтын мэдээллийн санд хүлээж авахад тавигдах шаардлага А. Хот байгуулалтын мэдээллийн сангийн стандартыг мөрдөх Б. Хийгдэж буй төслийн дэвсгэр зургийн WGS-848 UTM буюу солбицлын нэгдсэн тогтолцоонд хийж гүйцэтгэх <p>Бусад</p> <ul style="list-style-type: none"> - Дараах байгууллагуудтай заавал зөвшилцсөн байна - Улаанбаатар хотын Захирагчийн ажлын алба - Хот байгуулалт хөгжлийн газар - Улаанбаатар Цахилгаан түгээх сүлжээ ТӨХК - Хан-Уул дүүргийн Засаг даргын Тамгын газар - Хороодыг Засаг дарга нар - Холбогдох бусад байгууллагатай
12	Эдийн засгийн тооцоо, төсөв	<ul style="list-style-type: none"> - Эдийн засгийн тооцоо болон төсвийг БНБд 81-95-12 болон эрх бүхий байгууллагаас зөвшөөрсөн программаар тосцох
13	Онцгой нөхцөл	<ul style="list-style-type: none"> - Тохижилтын стандарт мөрдөн төлөвлөх

	<ul style="list-style-type: none">- Улаанбаатар хотын Нэг хот Нэг стандартыг мөрдөх- Цахилгаан шугам сүлжээ болон түүнтэй холбогдох барилга байгууламжийн угсралтын ажил гүйцэтгэхэд эдийн засгийн хувьд үр ашигтай орчин үеийн дэвшилтэд техник технологи нэвтрүүлэн ашиглах- Авто замын нэвтрэх хэсэгт төлөвлөсөн инженерийн шугам сүлжээний хонгилын системтэй уялдуулах- Зургийн ажлыг хийхдээ дүүрэг, хороо, ашиглагч байгууллагатай газар дээр нь очин судлах
--	--

ХЯНАСАН:

ХАН-УУЛ ДҮҮРГИЙН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН ТӨЛӨВЛӨЛТ, ГҮЙЦЭТГЭЛИЙН
ХЯНАЛТЫН ХЭЛТСИЙН ДАРГА  Л.ОТГОНБАЯР

БОЛОВСРУУЛСАН:

ХАН-УУЛ ДҮҮРГИЙН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН ТӨЛӨВЛӨЛТ, ГҮЙЦЭТГЭЛИЙН
ХЯНАЛТЫН ХЭЛТСИЙН АХЛАХ МЭРГЭЖИЛТЭН  О.МӨНГӨНШАГАЙ



Цахилгаан хангамжын зураг төслийн

"ОРГИЛТ-ОД" ХХК

Тусгай зөвшөөрлийн дугаар: ЗТ11-894/18

Хаяг: УБ хот. СБД 6-р хороо, 23-р байр 03 тоом

Утас: 96599090, 99139110



ЕГ шифр: OD-02/2023

**УЛААНБААТАР ХОТ, ХАН-ЧУЛ ДҮҮРГИЙН 13 ДУГААР ХОРООНЫ
5А ХЭСГИЙН АЙЛ ӨРХҮҮДИЙН ЦАХИЛГААНЫ ХҮЧДЭЛ САЙЖРУУЛАХ
АЖЛЫН ЗУРАГ ТӨСӨЛ**

Захиалагч		Боловсруулсан	
Албан тушаал	Нэр	Албан тушаал	Нэр
Хан-Чул Дүүргийн Засаг Даргын Тамгын Газрын дарга	С.Энхбаяр	"Оргилт-Од" ХХК-ийн захирал	Б.Мөнхзолбоо

УЛААНБААТАР ХОТ
2023 ОН

Бүлэг-1. 6(10) болон 0.4кВ-ын цахилгаан дамжуулах агаарын болон кабель
шугамын трасс ажлын тоо хэмжээ, Материалын түүвэр

ШИФР: 0D-02/2023-I

ЗУРГИЙН ЖАГСААЛТ


Тэмдэглэл	Хуудасны нэр	Хуудасны дугаар
Бүлэг-1.	6(10) болон 0.4кВ-ын цахилгаан дамжуулах агаарын болон кабель шугамын трасс ажлын тоо хэмжээ, Материалийн түүвэр	
1	Зургийн жагсаалт, Иш татсан ба хавсаргасан баримт бичгийн жагсаалт	ГЦ-1
2	Тайлбар бичиг	ГЦ-2
3	Байршлын тойм М1:4000	ГЦ-3
4	Гадна цахилгааны трасс, цахилгаан дамжуулах кабель шугамын трасс, зөвшөөрөл М1:2000	ГЦ-4
5	Гадна цахилгааны трасс, М1:500	ГЦ-5
6	Гадна цахилгааны трасс, М1:500	ГЦ-6
7	Гадна цахилгааны трасс, М1:500	ГЦ-7
8	Гадна цахилгааны трасс, М1:500	ГЦ-8
9	Материалын түүвэр, угсралтын ажлын хэмжээ, кабелийн хүснэгт	ГЦ-9
10	6(10) кВ ЦДАШ-ын угсралтын ажлын хэмжээ	ГЦ-10
11	6(10) кВ-ын материалын нэгдсэн түүвэр	ГЦ-11
12	6(10) кВ-ын тулгуурын материалын түүвэр	ГЦ-12
13	0.4кВ ЦДАШ-ын угсралтын ажлын хэмжээ	ГЦ-13
14	0.4кВ-ын тулгуурын материалын түүвэр	ГЦ-14
15	0.4кВ ЦДАШ-ын материалын түүвэр, Тоолуурын самбарын материалын түүвэр	ГЦ-15
Бүлэг-2.	6(10)/0.4кВ-ын 400кВА чадалтай КТПН нэг маягийн зураг	
16	Зургийн жагсаалт, Тайлбар бичиг	ГЦ-16
17	Дэд өртөөний цахилгаан холболтын зарчмын схем	ГЦ-17
18	КТПН-ний ерөнхий байдал	ГЦ-18
19	КТПН-ний урдаас харсан байдал	ГЦ-19
20	0.4 кВ-ын урдаас ба хажуугаас харсан байдал	ГЦ-20
21	КТПН-ний дээрээс харсан ба урдаас харсан байдал	ГЦ-21
22	Газардуулах байгууламжийн холболт	ГЦ-22
23	Газардуулах байгууламжийн гагнуурын холболт	ГЦ-23
24	КТПН-ын суурийн байгуулалт	ГЦ-24
25	КТПН-ын суурийн байгуулалт	ГЦ-25
26	Хашааны байгуулалт	ГЦ-26
27	Газардуулгын тооцоо	ГЦ-27
28	КТПН-ын захиалгын хуудас, угсралтын ажлын хэмжээ	ГЦ-28
29	Кабель тэмдэг, түүнийг шуудуунд байрлуулах	ГЦ-29
Бүлэг-3.	6(10), 0.4 кВ-ын ЦДАШ болон кабель шугамын нэг маяг	
30	Зургийн жагсаалт, Тайлбар бичиг	ГЦ-30
31	Тайлбар бичиг	ГЦ-31
32	Тайлбар бичиг	ГЦ-32
33	Завсрын тулгуур П10-9δ ерөнхий байдал	ГЦ-33
34	Төмөр бетон тулгуурын тулаас хийх ерөнхий байдал	ГЦ-34
35	Төмөр бетон анкер хуурай салгуур угсарч шугам салаалах	ГЦ-35
36	0.4кВ-ын Тулгууруудын төрөл	ГЦ-36
37	0.4кВ-ын Тулгууруудын төрөл	ГЦ-37
38	0.4кВ-ын Завсрын дан утастай тулгуур ПН2	ГЦ-38
39	0.4кВ-ын Завсрын давхар утастай тулгуур ПН3	ГЦ-39

Тэмдэглэл	Хуудасны нэр	Хуудасны дугаар
40	0.4кВ-ын Эргэлтийн дан утастай анкер тулгуур УПН2	ГЦ-40
41	0.4кВ-ын Эргэлтийн давхар утастай анкер тулгуур УПН3	ГЦ-41
42	0.4кВ-ын Өнцгийн дан утастай анкер тулгуур УАН2	ГЦ-42
43	0.4кВ-ын Өнцгийн давхар утастай анкер тулгуур УАН3	ГЦ-43
44	0.4кВ-ын Салбаралтын дан утастай анкер тулгуур АКН2	ГЦ-44
45	0.4кВ-ын Салбаралтын давхар утастай анкер тулгуур АКН3	ГЦ-45
46	0.4кВ-ын Төгсгөлийн дан утастай анкер тулгуур АКН2	ГЦ-46
47	0.4кВ-ын Тулаас тогтоогч Тулаастай тулгуур	ГЦ-47
48	0.4кВ-ын М холбогч U бүслүүр	ГЦ-48
49	0.4кВ-ын Тулгуурын газардуулах байгууламж	ГЦ-49
50	0.4кВ-ын Тулгуурын газардуулах, Бүслүүр	ГЦ-50
51	0.4кВ-ын Хэсэглэл	ГЦ-51
52	Кабелийн шуудууны огтлол	ГЦ-52
53	Кабелийн шуудууны огтлол	ГЦ-53
Бүлэг-4.	Тоолуурын самбарын нэг маягийн зураг	
54	Зургийн жагсаалт, Тайлбар бичиг	ГЦ-54
55	ТС-6 тоолуур автоматуудын байрлуулалт	ГЦ-55
56	Тоолуурын самбарын байрлуулалт	ГЦ-56
57	ТС-3 тоолуур автоматуудын байрлуулалт	ГЦ-57
58	Тоолуурын самбарын байрлуулалт	ГЦ-58
59	Тоолуурын самбарыг бетон тулгуурт бэхлэх/эхлэл/	ГЦ-59
60	ТС-ыг бетон тулгуурт бэхлэх/төгсгөл/ ТС-ын утас, кабелийн бэхлэгч	ГЦ-60
61	Тоолуурын самбарыг тулгуурт байрлуулах	ГЦ-61
62	Тоолуурын самбарыг тулгуурт байрлуулах	ГЦ-62
63	Газардуулгын байрлуулалт	ГЦ-63
Бүлэг-5.	6(10)кВ-ын Бүрээстэй цахилгаан дамжуулах агаарын шугамын нэг маягийн зураг	ХТ-1-7

ИШ ТАТСАН БА ХАВСАРГАСАН БАРИМТ БИЧГИЙН ЖАГСААЛТ

Тэмдэглэгээ	Нэр	Тайлбар
1	Иш татсан баримт бичиг	
2	Кабелийн шуудуунд тавих альбом	
3	Хавсаргасан баримт бичиг	

Энэхүү зураг төсөл нь "Оргилт-Од" ХХК-ний ОЮУНЫ ӨМЧ тул зохиогчийн зөвшөөрөлгүй өөрчлөх болон олшруулахыг хориглоно.

 БАРИМТЫН ЗУРАГ, ТӨСӨЛ "ОРГИЛТ-ОД" ХХК Улаанбаатар ORGILT_OD@yahoo.com Утас: 99139110, 77319110	УЛААНБААТАР ХОТ, ХАН-УУЛ ДҮҮРГИЙН 13 ДУГААР ХОРООНЫ 5А ХЭСГИЙН АЙЛ ӨРХҮҮДИЙН ЦАХИЛГААНЫ ХҮЧДЭЛ САЙЖРУУЛАХ АЖЛЫН ЗУРАГ ТӨСӨЛ				Ye шат: А.3
	Зургийн жагсаалт, тайлбар бичиг, материалын түүвэр				
	Инженер	О.Омгонцацрал	Е.Г.Шифр: OD-02/2023	Масштаб: А3@ М1:	Огноо: 2023-06
	Гүйцэтгэсэн	О.Омгонцацрал	Т.Г.Шифр:	Зургийн дугаар: ГЦ-1	Бүх хуудас: 63
Шалгасан	Г.Наранцэцэг				

ТАЙЛБАР

1. ЗУРГИЙН ДААЛГАВАР.

Улаанбаатар хот, Хан-Уул дүүргийн 13 дугаар хорооны 5А хэсгийн айл өрхүүдийн цахилгааны хүчдэл сайжруулах ажлын зураг төслийг хийж гүйцэтгэхдээ. УБЦТС ТӨХК-ийн 2021 оны 10-р сарын 29-ны өдөр гаргасан №15/05354/21 тоот техникийн нөхцөл. ХУД-ийн ЗДТГ-аас 2021 оны 09-р сарын 09-ны өдрийн зургийн даалгавар, ерөнхий төлөвлөгөөний ажлын зураг төсөл, газар дээр нь хийсэн судалгааг үндэслэн цахилгаан байгууламжийн дүрэм БД43-101-03-ын дагуу хийж гүйцэтгэв.

2. ЦАХИЛГААН ХАНГАМЖ.

Уг ерөнхий төлөвлөгөөний айл өрхүүд нь цахилгаан хангамжийн найдвартай ажиллагааны III зэргийн хэрэглэгч байна. 35/6 кВ-ын Био /шинэ/ дэд станцаас 6кВ-ын Шувуу-2 фидерийн тулгуур №148-д хуурай салгуур суурилуулан кабель шугам татаж шинээр баригдах дэд өртөөг тэжээх. 120-ЦА ХТП-0174-ийн 0,4кВ-ын хороо гаргалгаас одоо холбогдсон хэрэглэгчдийг шинээр баригдах дэд өртөөнд шилжүүлэн холбох.

3. ЦАХИЛГААН ДАМЖУУЛАХ АГААРЫН ШУГАМ.

0.4кВ-ын ЦДАШ-д 3x70+1x54.6мм²-ийн хөнгөнцагаан голтой өөрийгөө даагч СИП-2А дамжуулагч утас, газардуулгын тольтой тулгуур ашиглана. 0.4кВ-ын хуваарилах самбарыг тэжээхдээ АВБШВ 3x35+1x25мм² хөнгөнцагаан кабель хэрэглэнэ. Одоо байгаа модон тулгуур, Тоолууртай самбар, ЦДАШ-г буулгах.

Тулаасны баганыг тулгуурт 30°-ийн өнцгөөр налуулж газарт нүх ухаж суулгана.

Төмөр бетон тулгуурт дараах төмөр хийцүүд орно. Үүнд: Хөндлөвч, хөндлөвчийн бүслүүр, толгой, завсрын холбогч, тулаасны бэхэлгээ, тулаасны бүслүүр байна.

- Бүх төмөр хийцийг БД43-101-03ын 2.5.12-ын дагуу ээврэлтээс хамгаалж цайрдсан байна.
- Бүслүүрүүдийн баганатай харьцах хэсгийг халуунаар давтаж хавтгайлсан байна.

0.4кВ-ын ЦДАШ-д 10м урттай УКШ10-30.17 маягийн төмөр бетон конусан шон хэрэглэнэ. 0.4кВ-ын ЦДАШ-д СИП-2А маягийн өөрийгөө даагч бүрээстэй дамжуулагч хэрэглэнэ.

4. ДЭД СТАНЦ.

Олон улсын стандартын шаардлага хангасан, алдагдал багатай 400кВа чадалтай, 6,10кВ-ын хүчдлийн түвшинд шилжин ажиллах боломжтой 6(10)/0.4кВ-ын хүчдлийн хүчдэл тохируулгын 5 шатлалтай трансформатор бүхий дэд өртөөг шинээр барих.

5. 0.4 КВ-ЫН ХУВААРИЛАХ САМБАР.

ЩЭ маягийн тоос, ус чийгнээс хамгаалагдсан IP65 хамгаалалтын зэрэглэл бүхий тоолууртай металл самбарыг 0.4кВ-ын ЦДАШ-ын тулгуурт бүслүүрдэж бэхлэнэ. Уг самбарт тоолуурт засвар үйлчилгээ хийхэд хүчдэлийг таслахад зориулагдсан ачаалал таслагч, айл өрхүүдийн цахилгаан эрчим хүчний хэрэглээг тооцоолох идэвхит чадлын олон тарифт электрон тоолуур, 1 туйлт шугамын хамгаалах хэрэгсэл дуюу автомат таслуурыг айлын тоогоор суурилуулна. Мөн тоолууртай самбарын оролт дээр 3-н туйлт автомат таслуур болон айл өрхийн цахилгаан хэрэгслийг шатахаас хамгаалсан хэт хүчдэл хязгаарлагчийг суурилуулна.

6. ГАЗАРДУУЛГА.

0.4кВ-ын тулгуур болон тулгуур дээр суурилуулах самбар, шинээр барих дэд станц, төмөр бетон тулгуур, ЦДАШ-ын тулгуур дээрх бүх металл хийцийг газардуулсан байна. СИП утасны давтан газардуулгыг 200м тутамд хийнэ.


Төмөр бетон тулгуурын газардуулгын эсэргүүцэл жилийн аль ч улиралд 30 Ом-оос ихгүй байх ёстой. Анкерын тулгуурт цэнэг шавхагчийн газардуулгад холбогдож байгаа металл хэсэг нь будагзгүй байх шаардлагатай.

- Газардуулгын хэвтээ хүрээг 40x4мм-ийн туузан төмрөөр хийнэ. Үүнийг газрын тэгшлэгдсэн түвшнээс доош 0.5-0.7м-ийн гүнд шуудуунд суулгана.
- Босоо электродыг 3м-ийн урттай 50x50x5мм-ийн булан төмрөөр хийнэ. Босоо электродыг газарт өрөмдөж суулгана.
- Босоо болон хэвтээ электродыг хооронд нь гагнуураар холбоно.
- Тулгуурын газардуулгын эсэргүүцэл жилийн аль ч улиралд 30 Ом-оос ихгүй байх ёстой. Мөн 0.4кВ-ын ЦДАШ-ын тулгуур дээр суурилуулах металл самбарын газардуулгын эсэргүүцэл 30 омоос ихгүй байна.
- Хэрэв газардуулгын байгууламжийг хийж гүйцэтгэсний дараа эсэргүүцлийг хэмжиж дээр зааснаас их байх тохиолдолд электрод нэмж зоох замаар заавал дээр заасан хэмжээнд газардуулгын эсэргүүцлийг барилна.

7. АНХААРАХ.

Бүх угсралтын ажлыг БД43-101-03, БНБД 3.05.06-90-ийн дагуу мэргэжлийн эрх бүхий байгууллагаар хийлгэх ба бүх инженер техникийн болон бусад ажилчид ААД, ТААД-ийг чанд хатуу мөрдөж ажиллана. Гүйцэтгэгч зохиогчийн зөвшөөрөлгүйгээр ямар нэг өөрчлөлт хийхийг хориглох ба угсралтын ажлыг явцад тус компанийн харьяа түгээх төвийн хяналтан доор хийж гүйцэтгэнэ.

Энэхүү зураг төсөл нь "Оргилт-Од" ХХК-ний ОЮУНЫ ӨМЧ тул зохиогчийн зөвшөөрөлгүй өөрчлөх болон олшруулахыг хориглоно.

 <p align="center">УЛААНБААТАР ХОТ, ХАН-УУЛ ДҮҮРГИЙН 13 ДУГААР ХОРООНЫ 5А ХЭСГИЙН АЙЛ ӨРХҮҮДИЙН ЦАХИЛГААНЫ ХҮЧДЭЛ САЙЖРУУЛАХ АЖЛЫН ЗУРАГ ТӨСӨЛ</p>				
Тайлбар бичиг				Үе шат: А.3
